

**АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР
СУДАЛГАА ШИНЖИЛГЭЭНИЙ АЛБА**

**УЛС ТӨР, ХУУЛЬ ХЯНАЛТЫН
БАЙГУУЛЛАГЫН ХҮРЭЭН ДЭХ
АВЛИГЫН ТАЛААРХ ТӨСӨӨЛЛИЙН
2013 ОНЫ СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

**УЛААНБААТАР ХОТ
2014 ОН**

Хянан тохиолдуулсан: Д.Дуламсүрэн /Авлигатай тэмцэх газрын
Судалгаа шинжилгээний албаны дарга/

Хэвлэлд бэлтгэсэн: Ц.Шинэбаяр /Авлигатай тэмцэх газрын
Судалгаа шинжилгээний албаны ахлах ажилтан/

Эх бэлтгэлд: 2014 оны 3 дугаар сарын 25-нд

Хэвлэлтэд: 2014 оны 3 дугаар сарын 31-нд

Цаасны хэмжээ: 60x84/8

Хэвлэлийн хуудас: 7 х.х

Хэвлэсэн тоо: 1150 ш

“Уран гар пресс” ХХК-д эхийг бэлтгэж хэвлэв

© Авлигатай тэмцэх газар, 2014 он

Зохиогчийн зөвшөөрөлгүйгээр хэвлэн олшруулахыг хориглоно.

Агуулга

ӨМНӨХ ҮГ	v
СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ.....	vi
Судалгааны үндэслэл, зорилго	vi
Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн үзүүлэлт, түүнийг тооцсон арга зүй.....	vi
Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын төсөөллийн үзүүлэлт, судалгааны хамрах хүрээ	vii
СУДАЛГААНЫ ҮР ДҮН	1
УЛС ТӨРИЙН ХҮРЭЭНИЙ АВЛИГЫН ТАЛААРХ ШИНЖЭЭЧДИЙН ТӨСӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭ	1
Авлига тархсан байдлын үнэлгээ.....	1
Албан тушаалтнуудын авлигад өртөх эрсдлийн үнэлгээ	2
Авлигыг нөхцөлдүүлэгч хүчин зүйлсийн үнэлгээ	3
Улс төрийн хүрээнд өөрт болон бусдад ашигтай давуу байдал бий болгох шийдвэр гаргуулахын тулд хийдэг үйлдлийн давтамжийн үнэлгээ.....	4
Улс төрчид өөрсдийн сонирхлоор болон бусдын захиалгаар төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд оролцож нөлөөлөх үйлдлийн тархцын үнэлгээ	5
Улс төрчдийн зүгээс төрийн зарим үйл ажиллагаанд нөлөөлж буй үйл ажиллагааны давтамжийн үнэлгээ	6
Улс төрийн хүрээний авлига голлон чиглэгдэж буй үйл ажиллагааны үнэлгээ	7
Авлигын хэлбэрүүдийн тархцын үнэлгээ	8
Авлигын үед хэрэглэдэг аргуудын тархцын үнэлгээ	9
Авлигын улмаас бий болсон хөрөнгө, орлогын зарцуулалтын хэлбэрийн тархцын үнэлгээ	10
Бизнес эрхлэгчид төрийн байгууллага, албан тушаалтантай хэлцэл хийхдээ авлигад зарцуулдаг хөрөнгийн тухайн хэлцлийн нийт үнийн дүнд эзлэх хувь	11
Авлигын өртөг	12
Авлигын тархцын үнэлгээ	12
Улс төр, хууль хяналтын байгууллага болон бусад бүлэглэлийн хоорондын харилцааны үнэлгээ.....	13
Улс төрийн бүлэглэлүүдийн хүчний үнэлгээ	14
Төрийн байгууллага дахь авлигыг бий болгоход нөлөөлж буй хүчин зүйлсийн үнэлгээ	15
Авлигыг бууруулахын тулд нэн тэргүүнд хэрэгжүүлэх шаардлагатай үйл ажиллагааны үнэлгээ.....	16
Шүүх эрх мэдэл, хууль сахиулах байгууллагын хүрээн дэх авлигын төсөөллийн судалгааны дүн	17
Шүүх, хуулийн байгууллагын авлигад өртөх эрсдлийн үнэлгээ	17
Хуулийн байгууллага дахь тодорхой үйл ажиллагааны авлигад өртөх эрсдлийн үнэлгээ	19
Авлига үүсэхэд нөлөөлж буй хүчин зүйлсийн үнэлгээ	20

Хуулийн байгууллагын албан тушаалтан бусад албан тушаалтны үйл ажиллагаанд нөлөөлөн оролцож буй хэлбэрүүдийн тархцын үнэлгээ.....	21
Ашигтай, давуу байдал бий болгох шийдвэр гаргуулахын тулд хэрэглэдэг үйлдлүүдийн давтамжийн үнэлгээ	22
Шүүх, хуулийн байгууллагын хүрээн дэх авлигын өртөг	23
Авлигын хэлбэрийн үнэлгээ.....	24
Авлигын улмаас бий болсон хөрөнгө, орлогын зарцуулалтын үнэлгээ.....	25
Шүүх, хуулийн байгууллагын хүрээн дэх авлигыг бууруулахад шаардлагатай арга хэмжээний ач холбогдлын түвшин.....	26
ДҮГНЭЛТ.....	27
САНАЛ, ЗӨВЛӨМЖ.....	28

ӨМНӨХ ҮГ

Төрөөс авч хэрэгжүүлж байгаа авлигын эсрэг тэмцлийн нэг хэсэг нь авлигын нөхцөл байдал, цар хүрээ, шалтгаан, хэлбэрийг бодитой, үнэн зөвөөр тогтоох явдал юм. Энэ үйл ажиллагааны хүрээнд Авлигатай тэмцэх газраас зохион байгуулдаг хэд хэдэн судалгааны нэг нь “Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх шинжээчдийн төсөөллийн судалгаа” юм.

Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх боломж бүрдүүлж өгдөг учраас авлигын шалтгаан нөхцөл, цар хүрээг судлан тогтоох нь чухал ач холбогдолтой.

Энэхүү судалгааг жил бүр зохион байгуулж явуулах чиг үүргийг Улсын Их Хурлын 2008 оны 13 дугаар тогтоолоор Авлигатай тэмцэх газарт даалгасан бөгөөд судалгааны үр дүн нь Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтын хэрэгжилтийг үнэлэх нэг шалгуур болдгоороо онцлог юм.

2013 оны судалгааны үр дүн нь өмнөх жилүүдийн үр дүн, дэд хэсгүүдийн үзүүлэлтүүдээс харьцангуй эерэг үнэлгээтэй байна. Ийнхүү Монгол Улс дахь улс төр, хууль сахиулах болон шүүх эрх мэдлийн хүрээн дэх авлигын хэмжээ буурсан гэж шинжээчид үзсэн нь төрөөс авч хэрэгжүүлж байгаа авлигын эсрэг олон талт үйл ажиллагааны үр дүн билээ.

Олон нийтэд толилуулж буй энэхүү судалгааны тайлан Монгол Улс дахь авлигын нөхцөл байдал, ялангуяа “том авлига” гэж онцлон нэрлэдэг улс төрийн хүрээний авлигын талаар тодорхой дүр зураг, төсөөлөл өгнө гэдэгт найдаж байна.

Судалгааны үр дүнг улам чанартай, өгөөжтэй, бодитой болгоход тус нэмэр болох саналаа харамгүй хуваалцахыг энэ тайлантай танилцаж байгаа эрхэм Танаас хичээнгүйлэн хүсье.

Энэхүү судалгаанд шинжээчээр оролцож хамтран ажилласан хүмүүстээ талархал илэрхийлье.

**АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮН КОМИССАР Н.ГАНБОЛД**

СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Судалгааны үндэслэл, зорилго

Монгол Улсын Их Хурлаас 2005 онд Мянганы хөгжлийн зорилтуудыг батлахдаа үндсэн найман зорилгоос гадна Хүний эрхийг баталгаажуулах, ардчилсан засаглалыг хөгжүүлэх, авлигын эсрэг тэмцэхэд чиглэсэн Мянганы хөгжлийн 9 дэх зорилгыг нэмж баталсан билээ.

Энэхүү зорилгын хүрээнд “Авлигыг үл тэвчих уур амьсгалыг нийгмийн бүх хүрээнд бий болгон хэвшүүлэх” гэсэн 24 дэх зорилтыг дэвшүүлсэн бөгөөд УИХ-ын 2008 оны 13 дугаар тогтоолоор энэхүү зорилтын хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлтээр “Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээнд дэх авлигын талаарх төсөөлөл” гэсэн үзүүлэлтийг тодорхойлж, холбогдох судалгааг явуулж, үр дүнг гаргаж мэдээлэх үүргийг Авлигатай тэмцэх газарт даалгасан болно.

Энэ чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор “Мянганы хөгжлийн 9 дэх зорилгод дэмжлэг үзүүлэх төсөл”-ийн багийн боловсруулсан арга зүйн дагуу Авлигатай тэмцэх газраас “Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээнд дэх авлигын талаарх төсөөлөл”-ийн судалгааг зургаа дахь жилдээ явуулан үр дүнг нэгтгэн гаргалаа.

Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээнд дэх авлигын талаарх төсөөллийн судалгаа нь улс төрийн болон хууль хяналтын байгууллагын хүрээнд дэх авлигын цар хүрээ, хэлбэр, шалтгаан нөхцөлийг шинжээчдийн үнэлгээгээр тодорхойлж, авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, хэрэгжилтийг үнэлж дүгнэхэд шаардлагатай мэдээллийг бүрдүүлэх ач холбогдолтой судалгаа юм.

Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээнд дэх авлигын талаарх төсөөллийн үзүүлэлт, түүнийг тооцсон арга зүй

Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээнд дэх авлигын талаарх төсөөллийн үзүүлэлт нь дараахь агуулгыг илэрхийлэх тоон үзүүлэлтүүдээс бүрдэнэ:

- Авлигын цар хүрээ, тархалт;
- Авлигад өртөх эрсдэл бүхий түвшин, салбар, байгууллага;
- Авлигын шалтгаан нөхцөл;
- Авлигын төрөл, хэлбэр, хэмжээ.

Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээнд дэх авлигын талаарх төсөөллийн үзүүлэлтийг Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээнд дэх авлигын талаарх шинжээчдийн төсөөллийн судалгааны дүнд үндэслэн тооцсон.

Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээнд дэх авлигын төсөөллийн үзүүлэлтийн үнэлгээг гаргахдаа, бүрдүүлэгч дэд үзүүлэлт тус бүрийн үнэлгээг 5 онооны хэмжээсээр (1

буюу огт үгүй, 5 буюу маш их) гаргаж, дэд үзүүлэлтүүдийн энгийн арифметикийн дунджаар тооцсон болно.

Энэ удаагийн судалгаагаар Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн үзүүлэлтийг: улс төрийн хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн үзүүлэлт; хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн үзүүлэлт гэсэн байдлаар тус тусад нь тооцов.


Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын төсөөллийн үзүүлэлт, судалгааны хамрах хүрээ

Судалгааны явцад *Улс төрийн хүрээ* гэдэгт бүх шатны сонгуулийн үр дүнгээр байгуулагдсан байгууллага, албан тушаалтан, төрийн өндөр, дээд албан тушаалтны үйл ажиллагаатай холбоотой нийгмийн харилцааг, *Хууль, хяналтын байгууллагын хүрээ* гэдэгт шүүх, прокурор, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нийгмийн харилцааг тус тус хамруулж авч үзэв.

Судалгаанд оролцох шинжээчдийг сонгохдоо улс төрийн болон хууль хяналтын байгууллагад ажилласан туршлага, тухайн хүрээний талаарх мэдээ, мэдээлэлтэй ажиллаж буй эсэх, тэдгээрт тулгуурласан судалгаа, дүн шинжилгээний ажил хийдэг эсэх, түүнчлэн өмнөх судалгаанд оролцож байсан эсэх зэрэг шалгуурыг харгалзан үзсэн болно. Энэ удаагийн судалгаанд улс төрийн хүрээг үнэлэх 13, хууль хяналтын байгууллагын хүрээг үнэлэх 13, нийт 26 шинжээчийг сонгож оролцуулав.

СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Монгол Улсын улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээнд авлигын талаарх шинжээчдийн төсөөллийн 2013 оны үнэлгээ **3.68** байна. Үүнийг 2012 оны судалгааны үр дүнтэй харьцуулахад 0.25 пунктээр буурчээ. Гэвч энэ үзүүлэлт нь улс төр, хууль хяналтын хүрээнд авлига түгээмэл оршсоор байгааг илэрхийлж байна. (Зураг 1).



Зураг 1. Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээнд авлигын төсөөллийн үнэлгээ

УЛС ТӨРИЙН ХҮРЭЭНИЙ АВЛИГЫН ТАЛААРХ ШИНЖЭЭЧДИЙН ТӨСӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭ

Авлига тархсан байдлын үнэлгээ

Монгол Улс дахь улс төрийн институцуудад авлига тархсан байдлыг 1 – огт үгүй, 2 – бага зэрэг, 3 – дунд зэрэг, 4 – их, 5 – маш их гэсэн үзүүлэлтийг ашиглан шинжээчдээр үнэлүүлэв.

2013 оны үнэлгээнд нийт 6 институц хамруулснаас улс төрийн намууд, Засгийн газар, яам, харьяа байгууллагуудад авлига тархсан байдал нь бусдаасаа харьцангуй их байна.

2013 оны үзүүлэлтийг 2012 оныхтой харьцуулбал Засгийн газар, бүх шатны Засаг дарга, Засаг даргын Тамгын газар, харьяа байгууллагууд, аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын түвшинд авлига тархсан байдлын үзүүлэлт буурч, бусад институцийн үзүүлэлт өссөн байна.

2008 оноос 2013 он хүртэлхи 6 жилийн дундаж үзүүлэлтээр Засгийн газрын түвшинд авлига тархсан байдал хамгийн өндөр, түүний дараа улс төрийн намууд болон нутгийн захиргааны байгууллагууд орж байна.

Судалгаанд хамрагдсан нийт улс төрийн институцуудад авлига тархсан байдлын дундаж үзүүлэлт нь 2008 оноос 2013 он хүртэлх хугацаанд аажим буурч байгаа нь эерэг үзүүлэлт болж байна.

Зураг 2. Авлига тархсан байдлын үнэлгээ



Институт / он	2008	2009	2010	2011	2012	2013
Улсын Их хурал	3.71	4.46	4.00	3.75	3.27	3.67
Ерөнхийлөгч		2.91	3.75	3.27	2.18	2.36
Засгийн газар, яам, төрийн бусад байгууллага	4.38	4.29	4.40	4.00	4.25	4.08
Нутгийн өөрөө удирдах байгууллага	3.77	3.62	3.25	3.55	3.67	3.54
Бүх шатны Засаг дарга, Засаг даргын Тамгын газар	4.14	4.23	3.83	4.08	4.08	3.69
Улс төрийн намууд	4.36	3.92	4.00	4.27	3.69	4.09

Хүснэгт 1. Авлига тархсан байдлын үнэлгээ [2008-2013 он]

Албан тушаалтнуудын авлигад өртөх эрсдлийн үнэлгээ


Шинжээчдээр төрийн захиргааны байгууллагын удирдах, гүйцэтгэх, туслах албан тушаалтнууд, төрийн үйлчилгээний албан хаагчдын авлигад өртөх эрсдлийг 2011-ээс 2013 онд 3 жил дараалан үнэлүүлсэн бөгөөд үнэлгээнд 1- эрсдэлгүй, 2- бага эрсдэлтэй, 3 – дунд зэргийн эрсдэлтэй, 4 - их эрсдэлтэй, 5 – маш их эрсдэлтэй гэсэн үзүүлэлтүүдийг ашигласан.

2013 оны байдлаар яамдын сайд, дэд сайд, Төрийн нарийн бичгийн дарга нар, мөн яамдын газар, хэлтэс, агентлаг, харъяа бусад байгууллагын удирдах албан тушаалтнуудын авлигад өртөх эрсдэл бусдаасаа харьцангуй өндөр буюу их эрсдэлтэй байна гэж шинжээчид үзжээ.

2013 оны үзүүлэлтийг 2012 оны үзүүлэлттэй харьцуулбал сайд, дэд сайд, Төрийн нарийн бичгийн дарга нарын авлигад өртөх эрсдлийн түвшин буурч, бусад албан тушаалтнуудынх нэмэгдсэн байна.

Төрийн захиргааны байгууллагын бүх түвшний удирдах албан тушаалтнуудын авлигад өртөх эрсдэл их байгаа нь анхаарал татаж байна.

Зураг 3. Албан тушаалтнуудын авлигад өртөх эрсдэл



Албан тушаалтнууд / он	2011	2012	2013
Төрийн захиргааны байгууллагын удирдлагын түвшинд /сайд, дэд сайд, ТНБД/	4.08	4.17	3.85
Төрийн байгууллагын захиргааны байгууллагын дунд шатны албан хаагч /яам агентлагийн газар, хэлтсийн болон салбар нэгжийн удирдлагууд/	4.23	3.46	3.69
Төрийн захиргааны байгууллагын гүйцэтгэх албан хаагч	3.58	2.77	3.00
Төрийн үйлчилгээний албан хаагч	3.38	2.83	3.00

Хүснэгт 2. Албан тушаалтнуудын авлигад өртөх эрсдэл /тоон үзүүлэлтээр/

Авлигыг нөхцөлдүүлэгч хүчин зүйлсийн үнэлгээ

Улс төрийн хүрээн дэх авлигыг нөхцөлдүүлэгч хүчин зүйлсийн үнэлгээнд нийт 7 хүчин зүйлсийг хамруулснаас улс төрийн томилгоо болон улс төрийн хүрээн дэх бизнес бүлэглэлүүдийн ашиг сонирхол зэрэг хүчин зүйлс 2013 онд авлига үүсэхэд илүүтэй нөлөөлсөн гэж шинжээчид үзсэн байна. 2008 оноос 2013 он хүртэлх нийт 6 жилийн дундаж үзүүлэлтээр дээр дурдсан хүчин зүйлс мөн л хамгийн өндөр үзүүлэлттэй гарсан байна.

2013 оны үзүүлэлтүүдийг 2012 оны үзүүлэлттэй харьцуулбал сонгуулийн өнөөгийн тогтолцоонд хамаарах үзүүлэлт харьцангуй их өссөн бол намын санхүүжилтийн механизмын үзүүлэх нөлөөлөл нилээд буурсан байна.

2008 оноос 2013 он хүртэлх 6 жилийн хугацаанд эдгээр 7 хүчин зүйлсийн дундаж нь бараг нэг түвшинд байгаа нь авлигыг нөхцөлдүүлж, үүсгэж байгаа эдгээр хүчин зүйлсийн нийт нөлөөлөл огт буурахгүй байгааг харуулж байна. Тиймээс эдгээрийг нийтэд нь анхааран үзэж зөв зохистой тогтолцоо бүрдүүлэхэд анхаарах шаардлагатай байна.

Зураг 4. Авлигыг нөхцөлдүүлэгч хүчин зүйлсийн үнэлгээ



Хүчин зүйлс	2008	2009	2010	2011	2012	2013
Сонгуулийн өнөөгийн тогтолцоо	4.14	4.10	3.83	3.45	3.64	4.08
Сонгуулийн санхүүжилтийн механизм	4.50	4.20	4.42	4.50	4.23	4.23
Намын санхүүжилтийн механизм	4.57	4.40	4.25	4.38	4.58	4.31
Улс төрийн томилгоо	4.71	4.80	4.42	4.46	4.69	4.69
УИХ-ын хууль санаачлах, тогтоох, хэрэгжилтэд нь хяналт тавих үйл ажиллагаан дахь ашиг сонирхлын зөрчил	3.79	4.30	3.83	4.33	4.08	4.08
ИТХ-ын шийдвэр гаргах үйл ажиллагаан дахь ашиг сонирхлын зөрчил	3.79	3.90	3.50	4.00	3.83	3.69
Улс төрийн хүрэн дэх бизнес бүлэглэлүүдийн ашиг сонирхлын зөрчил	-	-	4.75	4.69	4.69	4.62

Хүснэгт 3. Авлигыг нөхцөлдүүлэгч хүчин зүйлсийн үнэлгээ

Улс төрийн хүрээнд өөрт болон бусдад ашигтай давуу байдал бий болгох шийдвэр гаргуулахын тулд хийдэг үйлдлийн давтамжийн үнэлгээ

Өөрт ашигтай шийдвэрийг албан тушаалтнаар гаргуулахын тулд ямар үйлдлийг голлон хийдэг талаар 1 – огт үгүй, 2 – бага зэрэг, 3 – дунд зэрэг, 4 – их, 5 – маш их гэсэн үзүүлэлтээр шинжээчдээр үнэлүүлэхэд 2013 онд хөрөнгө мөнгө өгөх, олсон ашиг орлогоо хуваахаар амлах, өндөр цалинтай ажилд оруулах, албан тушаалд томилох, өр зээлийг нь төлөх зэрэг үйлдлүүд их давтамжтай байна (Зураг 5).

2013 оны үзүүлэлтийг 2012 оны үзүүлэлттэй харьцуулж үзэхэд өндөр цалинтай ажилд оруулах үйлдлийн давтамж харьцангуйгаар хамгийн их нэмэгдэж, гадаад арга хэмжээний зардал даах, аялал жуулчлалын зардал даах, бэлэг өгөх үйлдлийн давтамж хамгийн их багассан байна (Зураг 5).

2008 оноос 2013 оны 6 жилийн дунджаар хөрөнгө мөнгө өгөх, албан тушаалд томилох, олсон ашиг орлогоо хуваахаар амлах, бэлэг өгөх үйлдлүүд хамгийн их давтамжтай байгаа тул авлигын өндөр эрсдэл бүхий албан тушаалтнуудын хөрөнгө, орлогоо мэдүүлж байгаа байдал, албан тушаалын томилгоо зэрэг асуудалд анхаарал хандуулах шаардлагатай.

Зураг 5. Өөрт ашигтай шийдвэр гаргуулахын тулд хийдэг үйлдлийн давтамж



Үзүүлэлт / үнэлгээ	2009	2010	2011	2012	2013
Олсон ашиг, орлогоо хуваахаар амлах	4.20	4.36	4.00	4.54	4.58
Мөнгө /хөрөнгө/ өгөх	4.70	4.42	4.15	4.67	4.58
Өндөр цалинтай ажилд оруулах	4.10	3.89	3.92	4.18	4.33
Албан тушаалд томилох	4.40	4.67	4.38	4.23	4.25
Өрийг нь төлөх	2.80	3.45	3.22	4.00	4.11
Өндөр үнэтэй бэлэг өөрт нь өгөх, авах	4.30	4.11	3.83	4.33	4.09
Сургалтын зардал даах	3.80	3.83	3.77	4.10	4.00
Гэр бүлийнхэнд нь өндөр үнэтэй бэлэг өгөх, авах	3.60	3.56	3.73	4.20	3.92
Бэлэг сэлт өгөх	4.70	4.45	4.00	4.58	3.92
Хэн нэгэнд зориулж албан тушаал шинээр бий болгох	4.00	4.00	4.00	3.77	3.82
Хувьцаа өгөх	2.70	3.33	3.36	3.67	3.70
Аялал, жуулчлалын зардал даах	3.90	4.09	4.08	4.36	3.62
Төрийн одон, медаль, салбарын тэргүүний ажилтан цол тэмдгээр шагнах	3.80	4.36	4.25	3.50	3.60
Гадаад банкинд данс нээж өгөх /мөнгө өгөх/	2.90	3.63	3.33	3.75	3.60
Гадаад арга хэмжээний зардал даах	3.80	4.33	4.08	4.45	3.54
Өндөр бооцоо тавьж тоглоомд санаатайгаар хожигдох	3.50	3.56	3.80	3.50	3.50
Эмчилгээ, сувилгааны зардал даах	3.60	3.82	3.60	3.75	3.36

Хүснэгт 4. Ашигтай шийдвэр гаргуулахын тулд ашигладаг үйлдлийн давтамж


Улс төрчид өөрсдийн сонирхлоор болон бусдын захиалгаар төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд оролцож нөлөөлөх үйлдлийн тархцын үнэлгээ

Улс төрчдийн зүгээс өөрсдийн хувийн ашиг сонирхлын үүднээс төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд хөндлөнгөөс хэрхэн нөлөөлдөг талаар 1 – огт үгүй, 2 – бага зэрэг, 3 – дунд зэрэг, 4 – их, 5 – маш их гэсэн үзүүлэлтээр шинжээчдээр үнэлгээ хийлгэхэд 2013 онд улс төрчдийн зүгээс албан тушаалтнуудад янз бүрийн байдлаар дарамт шахалт үзүүлэх үйлдлийг хамгийн их гаргасан гэж үзсэн ба бусад үйлдлийг, тухайлбал хууль бус шаардлага тавих гэх мэт үйлдлийг мөн их гаргасан байна.

2013 оны үзүүлэлтийг 2012 оны үзүүлэлттэй харьцуулбал дарамт шахалт үзүүлэх үйлдлийн тархац бараг 0.5 пунктээр нэмэгдэж, харин бусдын хооронд зуучлах нэрийдлээр мөнгө нэхэх үйлдлийн тархац мөн хэмжээгээр буурчээ.

2009 оноос 2013 он хүртэлх 5 жилийн дунджаар албан тушаалтныг гаргасан зөрчлөөр нь дарамталж шахалт үзүүлэх үйлдлийн тархац хамгийн өндөр үзүүлэлттэй, шан харамж шууд нэхэх үйлдлийн тархац харьцангуй бага үзүүлэлттэй байна. Иймээс улс төрчдийн зүгээс төрийн албан хаагчдад дарамт шахалт үзүүлэх явдлыг таслан зогсоох талаар анхаарах шаардлагатай.

Зураг 6. Улс төрчдийн нөлөөллийн хэлбэрийн тархац /2012, 2013 он/



Үзүүлэлт / үнэлгээ	2009	2010	2011	2012	2013
Дарамт шахалт үзүүлэх /ажлаас нь хална, арга хэмжээ авна гэх мэт/	4.00	3.83	4.00	3.62	4.08
Шан харамж нэхэх	3.90	3.27	3.50	3.70	3.67
Бусдын хооронд зуучлах нэрийдлээр мөнгө нэхэх	3.90	3.70	3.75	4.10	3.64
Хууль бусаар дотоод үйл ажиллагаанд нь оролцох	3.70	3.67	3.91	3.82	3.85
Хууль бус шаардлага тавих	3.60	3.67	3.92	3.92	3.69
Албан тушаалтны зөрчлийг илрүүлж түүгээр нь дарамтлах	4.40	4.09	4.00	4.17	3.92

Хүснэгт 5. Улс төрчдийн нөлөөллийн хэлбэрүүдийн тархцын үнэлгээ /2009-2013/

Улс төрчдийн зүгээс төрийн зарим үйл ажиллагаанд нөлөөлж буй үйл ажиллагааны давтамжийн үнэлгээ

2013 онд улс төрчдийн зүгээс шүүхийн үйл ажиллагаа, төрийн албаны томилгоо, тусгай зөвшөөрөл олгох, тусгай зөвшөөрлийг сунгах, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа зэрэг үйл ажиллагаанд илүүтэй нөлөөлж хөндлөнгөөс оролцсон гэж шинжээчид үзсэн байна. Үнэлгээнд 1 – огт нөлөөлдөггүй, 2 – бага зэрэг нөлөөлдөг, 3 – дунд зэрэг нөлөөлдөг, 4 – их нөлөөлдөг, 5 – маш их нөлөөлдөг гэсэн үзүүлэлтийг ашигласан.

2013 оны судалгааны үзүүлэлтийг 2012 оныхтой харьцуулбал хяналтын байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлж буй үйл ажиллагааны давтамж хамгийн ихээр буюу 0.5 пунктээр буурсан нь эерэг үзүүлэлт болж байна.

2008 оноос 2013 он хүртэлхи 6 жилийн хугацааны дундаж үзүүлэлтээр улс төрчид төрийн албаны томилгоо, тусгай зөвшөөрөл авах, тусгай зөвшөөрөл сунгах үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох болон төрийн үйлчилгээг давуу байдлаар хүртэх замаар төрийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж байсан гэж шинжээчид үзсэн байна.

Зураг 7. Улс төрчдийн зүгээс төрийн үйл ажиллагаанд нөлөөлж буй давтамжийн үнэлгээ /2012, 2013 он/



Үзүүлэлт / үнэлгээ	2008	2009	2010	2011	2012	2013
Төрийн үйлчилгээг давуу байдлаар хүртэх	4.00	4.30	4.36	4.15	4.42	4.15
Тусгай зөвшөөрөл авах, сунгуулах	4.57	4.50	4.45	4.58	4.23	4.31
Татварын асуудлыг явцуу ашиг сонирхолд нийцүүлэн шийдвэрлүүлэх	3.47	3.60	4.56	4.18	3.75	3.91
Шүүхийн үйл ажиллагаанд нөлөөлөх	3.67	3.90	4.20	4.50	4.27	4.42
Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах ажиллагаанд нөлөөлөх	4.00	4.10	4.09	4.50	4.09	4.08
Хяналтын байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх	3.79	4.00	4.27	4.50	4.33	3.85
Хууль, эрх зүйн шинжтэй шийдвэр гаргах үйл ажиллагаанд	4.00	3.90	4.18	4.33	4.27	3.92
Ажил, албан тушаалд томилох ажиллагаанд нөлөөлөх	4.79	4.60	4.64	4.67	4.38	4.38

Хүснэгт 6. Улс төрчдийн зүгээс төрийн үйл ажиллагаанд нөлөөлж байгаа давтамжийн үнэлгээ /2008-2013 он/

Улс төрийн хүрээний авлига голлон чиглэгдэж буй үйл ажиллагааны үнэлгээ

Улс төрийн хүрээний авлига голлон чиглэгдэж буй үйл ажиллагааны үнэлгээг 1 – огт үгүй, 2 – бага зэрэг, 3 – дунд зэрэг, 4 – их, 5 – маш их гэсэн үзүүлэлтээр шинжээчид үнэлсэн бөгөөд 2013 оны үнэлгээгээр улс төрийн хүрээний авлига газар тариалангийн салбарын үйл ажиллагаанд дунд зэрэг, үнэлгээнд хамруулсан бусад 8 төрлийн үйл ажиллагаанд их хэмжээгээр чиглэгдэж байгаагаас уул уурхайн салбарын үйл ажиллагаа, бизнест болон намд эрх мэдлээ тогтоох үйл ажиллагаа, дэд бүтцийн салбарын үйл ажиллагаатай холбоотой үзүүлэлтүүд хамгийн өндөр нь байна [Зураг 8].

2013 оны судалгааны үр дүнг 2012 оны үр дүнтэй харьцуулбал хэвлэл мэдээллийн салбартай холбоотой улс төрийн авлигын үйл ажиллагаа хамгийн ихээр нэмэгдсэн бөгөөд газар тариалангийн салбартай холбоотой улс төрийн авлигын үйл ажиллагаа буурсан байна.

2009 оноос 2013 он хүртэлх 6 жилийн дундаж үзүүлэлтээр уул уурхайн салбарын үйл ажиллагаа, улс төрийн намын үйл ажиллагаа, дэд бүтцийн салбарын үйл ажиллагаанд улс төрийн авлига голлон чиглэгдэж байжээ.

Зураг 8. Улс төрийн үйл ажиллагаа голлон чиглэгдэж буй үйл ажиллагааны үнэлгээ /2012, 2013 он/



Үзүүлэлт / үнэлгээ	2009	2010	2011	2012	2013
Дэд бүтцийн бүтээн байгуулалт	4.50	4.17	4.30	4.45	4.31
Уул уурхайн салбар	4.67	4.42	4.54	4.33	4.38
Намд эрх мэдлээ тогтоох	4.55	4.42	4.33	4.20	4.33
Бизнест эрх мэдлээ тогтоох	4.27	4.45	3.92	4.18	4.36
Орон сууц, барилга байгууламж барихад	4.08	3.92	4.23	4.08	4.15
Өмч хувьчлал	3.73	4.10	4.20	4.00	4.08
Гадаадын хөрөнгө оруулалт	3.82	3.92	4.17	4.00	3.91
Хэвлэл мэдээллийн хэрэгсэл	4.38	4.27	4.54	3.67	4.08
Газар тариалан	3.60	3.00	3.25	3.40	3.09


Хүснэгт 7. Улс төрийн авлига голлон чиглэгдэж буй үйл ажиллагааны үнэлгээ

Авлигын хэлбэрүүдийн тархцын үнэлгээ

2013 онд улс төрийн хүрээнд намд хандив авах, лоббидох, төрийн өмчийг завших, санал худалдан авах, хууль бус хандив авах зэрэг авлигын хэлбэрүүд харьцангуй илүү түгээмэл байсан гэж шинжээчид үзсэн байна. Үнэлгээнд 1 – огт байхгүй, 2 – бага зэрэг түгээмэл, 3 – дунд зэрэг, 4 – их түгээмэл, 5 – маш их түгээмэл гэсэн үзүүлэлтийг ашигласан.

2009 оноос 2013 он хүртэлх 5 жилийн дунджаар намд хандив авах, ашиг сонирхолдоо нийцсэн шийдвэр гаргах болон гаргуулахаар лоббидох, улс төрийн зорилгоор хууль бус хандив авах, өгөх, сонгогчдын саналыг худалдан авах зэрэг хэлбэрүүд илүү түгээмэл байснаас үзвэл улс төрийн авлигын хэлбэрүүд дотроос улс төрийн нам, сонгуулийн үйл ажиллагаатай холбоотой авлигын хэлбэрүүдэд илүүтэй анхаарал хандуулах шаардлагатай болох нь харагдаж байна.

Зураг 9. Авлигын хэлбэрүүдийн тархацын 2012, 2013 оны үнэлгээ



Үзүүлэлт / үнэлгээ	2009	2010	2011	2012	2013
Төрийн өмчийг шамшигдуулах, хувьдаа завших	4.00	4.00	4.08	3.92	4.00
Өөрийн өмчийн компани, аж ахуйн нэгжид давуу байдал бий болгох	4.46	3.25	4.15	4.15	3.92
Ашиг сонирхолдоо нийцсэн шийдвэр гаргах, гаргуулахаар лоббидох	4.54	4.58	4.23	4.50	4.23
Төсвийн мөнгийг зориулалтын бусаар, өөрийн ашиг сонирхлоор зарцуулах	4.15	4.36	4.08	4.17	3.69
Бизнесийн бүлэглэлийн нөлөөнд автах, тэдний төлөө үйлчилж хууль санаачлан батлуулах	4.33	4.64	4.33	4.00	3.54
Сонгогчдын саналыг худалдан авах	4.69	4.50	4.31	3.91	4.00
Улс төрийн зорилгоор хууль бус хандив өгөх, авах	4.42	4.50	4.38	4.50	4.00
Өөрийн эрх мэдлээ худалдах	4.00	4.17	3.91	4.09	3.50
Мөнгө угаах	4.00	3.80	4.67	3.60	3.11
Намд хандив авах	4.42	4.25	4.62	4.50	4.38
Хувийн байгууллага, санд хандив авах	3.75	3.64	3.73	3.90	2.92
Хууль бусаар дампууруулах	3.56	3.56	3.78	3.50	3.22

Хүснэгт 8. Авлигын хэлбэрүүдийн тархцын 2009- 2013 оны үнэлгээ

Авлигын үед хэрэглэдэг аргуудын тархцын үнэлгээ

Улс төрийн авлигын хүрээнд хээл хахууль өгөх, авах аргуудын тархцыг 1 – огт үгүй, 2 – бага зэрэг, 3 – дунд зэрэг, 4 – их, 5 – маш их гэсэн үзүүлэлтээр үнэлсэн бөгөөд 2013 онд хамаарах бүхий этгээдэд давуу тал олгох, шууд өөрт нь өгөх, хувьцаа, эд хөрөнгө өмчлүүлэх, үйл ажиллагааны зардал болгож өгөх, мөрийтэй тоглож санаатай алдах зэрэг аргууд хамгийн өндөр үзүүлэлттэй байна.

2013 оны үзүүлэлтийг 2012 оны үзүүлэлттэй харьцуулбал хээл хахуулийн зүйлийг хахууль авагчид шууд өөрт нь өгөх болон мөнгө зээлдүүлээд мартагч гэсэн хоёр хэлбэрийн үзүүлэлт өссөн байх бөгөөд бусад 8 хэлбэрийн үзүүлэлт буусан байгаагаас зуучлагчаар дамжуулах, эд зүйлийг зах зээлийн үнээс доогуур үнээр худалдах, үйл ажиллагааны зардал маягаар хахууль өгөхтэй холбоотой үзүүлэлтүүд хамгийн ихээр буурчээ. Ойр дотнын хүн, гэр бүл гишүүд, тэдгээрийн компанид давуу тал олгох байдлаар илэрдэг хэлбэрийн үзүүлэлт 2012 оныхоос 2013 онд маш бага хэмжээгээр буурсан байх ба энэ хэлбэрийн үзүүлэлтийн 2009 оноос 2013 он хүртэлх дундаж нь хамгийн өндөр байна.

Зураг 10. Улс төрийн авлигын үед хэрэглэдэг аргуудын тархцын 2012, 2013 оны үнэлгээ



Үзүүлэлт / үнэлгээ	2009	2010	2011	2012	2013
Үйл ажиллагааны зардал болгож өгөх	3.36	4.27	3.50	4.33	3.64
Зуучлагчаар дамжуулах	4.10	4.09	4.00	4.11	3.18
Эд зүйлсийг зах зээлийн үнээс доогуур үнээр худалдах	3.50	3.45	3.78	4.11	3.27
Мөрийтэй тоглож санаатай алдах	3.44	3.75	3.90	4.08	3.60
Ойр дотны хүн, гэр бүлийн гишүүд, тэдгээрийн компанид давуу байдал олгох	4.20	4.08	3.90	4.08	4.00
Хувьцаа, эд хөрөнгө өмчлүүлэх	4.08	4.22	3.18	3.92	3.70
Ойр дотны хүмүүсээр дамжуулах	3.89	3.75	3.75	3.90	3.55
Эд зүйлсийг зах зээлийн үнээс дээгүүр үнээр худалдан авах	3.56	3.55	3.80	3.90	3.45
Шууд өөрт нь өгөх	3.45	3.80	3.33	3.67	3.91
Мөнгө зээлдүүлээд мартаx	3.00	3.56	3.40	3.38	3.50

Хүснэгт 9. Улс төрийн авлигын үед хэрэглэдэг аргуудын тархцын 2009- 2013 оны үнэлгээ

Авлигын улмаас бий болсон хөрөнгө, орлогын зарцуулалтын хэлбэрийн тархцын үнэлгээ

Улс төрийн хүрээнд авлигаар бий болсон хөрөнгө, орлогыг зарцуулж байгаа хэлбэрийг **1 – үгүй, 3 – эргэлзээтэй, 5 – энэ хэлбэрээр зарцуулдаг буюу тийм** гэсэн үзүүлэлтээр үнэлсэн бөгөөд 2013 онд хүүхдийн сургалтын төлбөр төлөх, үл хөдлөх хөрөнгө худалдан авах, хувийн компанид хөрөнгө оруулалт болгож оруулах, орон сууц, автомашин худалдан авах, сонгуулийн компанид ажилд зарцуулах, гадаадын банкинд хадгалах байдлаар болон зугаа цэнгэлд зарцуулсан байна.

2013 оны үзүүлэлтийг 2012 оны үзүүлэлттэй харьцуулбал авлигаар олсон хөрөнгийг өдөр тутмын хэрэгцээнд зарцуулах болон дотоодын банкинд хадгалах зэрэг хэлбэрт хамаарах үзүүлэлтүүд хамгийн их хэмжээгээр буюу 1 пунктээс илүү хэмжээгээр буурсан байх ба нийтдээ 4 хэлбэрийн үзүүлэлт буурчээ. Орон сууц худалдан авах болон өөрийн болон гэр бүлийн эзэмшлийн компанид хувь оруулахтай холбоотой үзүүлэлтүүд өөрчлөгдөөгүй бол үлдсэн 6 хэлбэрийн үзүүлэлт өссөн байгаагаас хүүхдийн сургалтын төлбөрт зарцуулах хэлбэрийн үзүүлэлт хамгийн өндөр буюу 1 пунктээр өссөн байна.

2009 оноос 2013 он хүртэлх 5 жилийн дундаж үзүүлэлтээр орон сууц худалдан авах, үл хөдлөх хөрөнгө худалдан авах, өөрийн болон гэр бүлийн эзэмшлийн компанид хувь оруулах, хүүхдийн сургалтын төлбөрт зарцуулах, автомашин худалдан авах зэрэг хэлбэрүүд хамгийн өндөр үзүүлэлттэй байна.

Зураг 11. Авлигын замаар олсон хөрөнгө, орлогын зарцуулалтын тархацын 2012, 2013 оны үнэлгээ



Хэлбэрүүд / хариулт	2009	2010	2011	2012	2013
Орон сууц худалдан авдаг	4.82	4.45	4.82	5.00	5.00
Өөрийн болон гэр бүлийн эзэмшлийн компанид хувь оруулдаг	4.60	4.27	4.78	5.00	5.00
Гадаадад үл хөдлөх хөрөнгө худалдаж авдаг	3.40	3.44	3.25	4.78	3.89
Үл хөдлөх хөрөнгө худалдан авдаг	4.82	4.45	4.80	4.75	5.00
Зугаа цэнгэлд зарцуулдаг	4.40	4.20	4.45	4.75	4.40
Өдөр тутмынхаа хэрэгцээнд зориулах	4.33	4.64	4.40	4.67	3.60
Дотоодын банкинд хадгалдаг	4.00	3.67	3.00	4.67	3.60
Машин худалдан авдаг	4.45	4.45	4.80	4.50	4.64
Дараагийн сонгуульд зарцуулах	3.25	4.00	3.60	4.43	4.50
Хүүхдийнхээ сургалтын төлбөрт зориулдаг	4.60	4.82	4.80	4.00	5.00
Гадаадын банкинд хадгалдаг	3.44	4.00	3.00	3.86	4.43
Хувьцаа худалдан авдаг	3.00	3.67	3.22	2.75	3.00

Хүснэгт 10. Авлигаар олсон хөрөнгийн зарцуулалтын хэлбэрийн 2009-2013 оны тархцын үнэлгээ

Бизнес эрхлэгчид төрийн байгууллага, албан тушаалтантай хэлцэл хийхдээ авлигад зарцуулдаг хөрөнгийн тухайн хэлцлийн нийт үнийн дүнд эзлэх хувь

Бизнес эрхлэгчдээс төрийн байгууллага, албан тушаалтантай хэлцэл хийх үед зарцуулдаг авлигын хэмжээг тухайн хэлцлийн нийт үнийн дүнд эзлэх хувиар тооцож үнэлсэн 2013 оны үзүүлэлтээр өмч хувьчлах шийдвэр гаргуулахад хувьчлах хөрөнгийн 16.3 хувийг, төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах шалгаруулалтын үед тендерийн 13.5 хувийг, татвараас чөлөөлүүлэхэд 13.1 хувийг, төсөл, хөтөлбөрт хамрагдахад тухайн төслийн 10 хувь, зээл авахад зээлийн 9.8 хувь, өр төлбөр, иргэний нэхэмжлэл шийдвэрлүүлэхэд өр төлбөр, нэхэмжлэлийн 8.9 хувийг авлигад зарцуулдаг гэж шинжээчид үзсэн байна.

2009 оноос 2013 он хүртэлх 5 жилийн дунджаар өмч хувьчлах шийдвэр гаргуулахад нийт хэлцлийн үнийн дүнгийн 17 хувийг авлигад зарцуулдаг гэсэн үзүүлэлттэй байгаа нь хамгийн өндөр үзүүлэлт байх бөгөөд 2013 оны судалгааны үр дүнгээр мөн энэ хэлбэр хамгийн өндөр үзүүлэлттэй байна.

Зураг 12. Бизнес эрхлэгчдээс төрийн байгууллагатай хэлцэл хийх үед зарцуулдаг авлигын хэлцлийн үнийн дүнд эзлэх хувь [2012, 2013 он]



Ажил үйлчилгээ / Үнийн дүнгийн хувь	2009	2010	2011	2012	2013
Төсөл, хөтөлбөрт хамрагдах	12.45	12.91	12.00	13.50	10.00
Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах шалгаруулалтад ялах	16.50	13.41	12.50	12.50	13.50
Өмч хувьчлах шийдвэр гаргуулах	15.78	15.83	16.94	20.00	16.25
Зээл авах	11.50	10.00	11.00	8.93	9.77
Өр төлбөр, иргэний нэхэмжлэл шийдвэрлүүлэх	11.08	11.00	14.64	12.50	8.86
Татвараас чөлөөлүүлэх	15.50	11.39	15.28	13.50	13.06


Хүснэгт 11. Бизнес эрхлэгчдээс төрийн байгууллагатай хэлцэл хийх үед зарцуулдаг авлигын хэлцлийн үнийн дүнд эзлэх хувь [2009- 2013 он]

Авлигын өртөг

Авлигад зарцуулж буй мөнгөний хэмжээг шинжээчдийн төсөөллөөр тодорхойлуулахад 2013 онд ажил, албан тушаалд орох үед дунджаар 10.9 сая төгрөг, тусгай зөвшөөрөл авахад дунджаар 16.5 сая төгрөг, ашиг сонирхолдоо нийцсэн хууль, шийдвэр гаргуулахад дунджаар 20 сая төгрөг зарцуулж байна гэсэн үзүүлэлт гарч байна.

2013 оны үзүүлэлтийг өмнөх оныхтой харьцуулбал ажил, албан тушаалд орох үед зарцуулдаг хээл хахуулийн дундаж хэмжээ 1.8 сая төгрөгөөр, тусгай зөвшөөрөл авах үед зарцуулдаг хээл хахуулийн дундаж хэмжээ 1.4 сая төгрөгөөр нэмэгдэж, ашиг сонирхолдоо нийцсэн хууль, шийдвэр гаргуулахад зарцуулдаг хээл хахуулийн дундаж хэмжээ 1.1 сая төгрөгөөр буурсан байна.

Зураг 13. Авлигад зарцуулж буй мөнгөний хэмжээ [сая төгрөгөөр]



Үйлдэл / Он	2011	2012	2013
Ажил, албан тушаалд орох	16.1	9.1	10.9
Тусгай зөвшөөрөл авах	15.5	15.1	16.5
Ашиг сонирхолдоо нийцсэн хууль, шийдвэр гаргуулах	22.1	21.1	20.0

Хүснэгт 12. Авлигад зарцуулж буй мөнгөний дундаж хэмжээ [2011-2013 он]

Авлигын тархцын үнэлгээ

Төрийн байгууллагын ямар үйл ажиллагаанд авлига илүү байгаа талаар 1- огт үгүй, 2 – бага зэрэг, 3 – дунд зэрэг, 4 – их, 5 – маш их гэсэн үзүүлэлтээр шинжээчдээр үнэлүүлэхэд 2013 онд төрийн өмчийг захиран зарцуулах үйл ажиллагаа, хуулийг хэрэгжүүлэхэд хяналт тавих үйл ажиллагаа, төрийн хэрэгцээнд бараа, ажил үйлчилгээ худалдан авах үйл

ажиллагаа, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагаанд авлига харьцангуй илүү байна үзсэн байна.

2013 оны үзүүлэлтийг өмнөх оны үзүүлэлттэй харьцуулбал хуулийн хэрэгжилтэд хяналт тавих үйл ажиллагаан дахь авлига болон өмч хувьчлалын үйл ажиллагаан дахь авлига буурч, бусад 5 төрлийн үйл ажиллагаан дахь авлига өссөн байгаагаас ажил, албан тушаалын томилгоон дох авлига болон төрийн худалдан авалтын үйл ажиллагаан дахь авлигын хэмжээний өсөлт хамгийн өндөр байна.

2008 оноос 2013 он хүртэлх 6 жилийн судалгааны дундаж үзүүлэлтээр төсвийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах болон тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд авлига харьцангуй их байна.

Зураг 14. Авлигын тархцын 2012, 2013 оны үнэлгээ



Үзүүлэлт / үнэлгээ	2008	2009	2010	2011	2012	2013
Төрийн өмч, төсвийн хөрөнгийг захиран зарцуулах	4.27	4.38	4.42	3.67	4.58	4.42
Тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаа	4.80	4.69	4.83	4.46	4.31	4.00
Өмч хувьчлал	3.87	3.82	4.50	4.00	4.00	4.15
Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах	4.80	4.54	4.75	4.54	4.69	4.23
Төсөл, хөтөлбөрт хамруулан хэрэгжүүлэх ажиллагаа	4.13	4.08	4.25	3.85	4.25	4.15
Хуулийн хэрэгжилтэд хяналт тавих ажиллагаа	3.80	4.00	4.20	3.85	4.33	4.38
Ажил, албан тушаалд томилох	4.53	4.46	4.50	4.31	4.38	3.92


Хүснэгт 13. Авлигын тархцын 2008-2013 оны үнэлгээ

Улс төр, хууль хяналтын байгууллага болон бусад бүлэглэлийн хоорондын харилцааны үнэлгээ

Монгол Улс дахь улс төр, бизнес, хууль сахиулах байгууллага, бүлэглэлүүд, гаднын улс төр, бизнесийн бүлэглэлүүдийн хоорондын харилцааг 1 – үгүй, 3 – магадгүй, 5 – тийм гэсэн үзүүлэлтээр үнэлсэн шинжээчид Монгол Улсад улс төрийн авлига илүү далд хэлбэрт шилжсэн, бизнесийн бүлэглэлүүд улс төрчдийг гартаа оруулсан, улс төр, бизнесийн

бүлэглэл өөр хоорондоо нэгдсэн гэдэгтэй санал нэгдсэн байна. Сүүлийн 5 жилийн судалгааны дундаж үзүүлэлтүүд нь мөн адил үр дүнтэй байна.

Зураг 15. Улс төр, бизнесийн бүлэглэлүүдийн харилцааны үнэлгээ /2012, 2013 он/



Үзүүлэлт	2009	2010	2011	2012	2013
Улс төрчид бизнесийн бүлэглэлийг гартаа оруулсан	2.23	3.50	2.83	3.60	3.73
Бизнесийн бүлэглэл улс төрчдийг гартаа оруулсан	4.69	4.50	4.69	4.20	4.23
Улс төр, бизнесийн бүлэглэл нэгдсэн	4.67	4.67	4.33	4.54	4.08
Улс төрийн нам /бүлэглэл/ гэмт бүлэглэлийг гартаа оруулсан	2.40	2.78	2.11	2.71	2.78
Улс төрийн нам /бүлэглэл/-ыг гэмт бүлэглэл гартаа оруулсан	2.80	3.40	2.83	2.00	3.00
Гадны улс төрийн бүлэглэл Монголын улс төрийн нам /бүлэглэл/-ыг гартаа оруулсан	3.18	3.73	3.00	2.27	2.67
Гадны бизнесийн бүлэглэл Монголын улс төрийн нам /бүлэглэл/-ыг гартаа оруулсан	4.11	3.91	2.64	3.00	3.20
Гадны улс төрийн бүлэглэл Монголын улс төрийн нам /бүлэглэл/-тай нэгдсэн	2.78	3.60	2.00	2.25	3.20
Гаднын бизнесийн бүлэглэл Монголын улс төрийн нам /бүлэглэл/-тэй нэгдсэн	-	-	2.00	4.00	1.40
Монголын улс төрийн нам /бүлэглэл/ гадны бизнесийн бүлэглэлийг гартаа оруулсан	1.22	1.40	1.55	1.00	1.20
Монголын улс төрийн нам /бүлэглэл/ гадны улс төрийн нам /бүлэглэл/-ыг гартаа оруулсан	1.20	3.00	3.20	1.00	4.00
Улс төрийн авлига нь илүү далд хэлбэрт шилжсэн	4.67	5.00	4.23	4.23	4.40
Улс төрчид хууль хяналтын болон цагдаагийн байгууллагатай хууль бус ашиг сонирхлоор нийлсэн	4.08	4.50	4.54	4.50	2.75

Хүснэгт 14. Улс төр, бизнесийн бүлэглэлүүдийн харилцааны үнэлгээ /2009-2013 он/

Улс төрийн бүлэглэлүүдийн хүчний үнэлгээ

Монгол Улс дахь улс төрийн бүлэглэлүүдийн хүчний байдлыг 1 – үгүй, 2 – бага, 3 – дунд, 4 – их, 5 – маш их гэсэн үзүүлэлтээр шинжээчдээр үнэлүүлэхэд 2013 онд хувийн эрх ашгийг нэн тэргүүнд тавьсан, улс төрийн нам тойрсон болон нэг хүнийг тойрсон хүрээлэл,

хувийн эрх ашгийг урьтал болгосон бөгөөд бизнес дээр ашиг сонирхол нь нэгдэж нийлсэн хүрээлэл, хувийн эрх ашгийг урьтал болгосон нам дамжсан, нэг нутаг, нэг аймаг гэж нутгархсан хүрээлэл болон найз нөхдийн хүрээлэл давамгайлж байна гэж үзжээ. Нийтийн эрх ашгийн төлөө нэгдэж нийлсэн хүрээлэл маш сул байна.

2009 оноос хойшхи 5 жилийн судалгааны дундаж үзүүлэлтээр хувийн эрх ашгийг нэн тэргүүнд тавьсан улс төрийн нэг нам тойрсон болон нам дамжсан хүрээлэл болон бизнесийн хүрээлэл, хувийн эрх ашгийг урьтал болгосон нэг нутаг, аймаг тойрсон бүлэглэл, хүрээлэл зэрэг нийт 4 бүлэглэл, хүрээлэл илүү хүчтэй байна. Энэ нь улс төрийн хүрээнд нийтийн эрх ашиг бус хувийн эрх ашиг илүү давамгайлж, энэ байдал бизнесийн үйл ажиллагаа, улс төрийн намын үйл ажиллагаанд нэвтрээд байгааг харуулж байна.

Зураг 16. Улс төрийн бүлэглэлүүдийн хүчний үнэлгээ /2012, 2013 он/




Бүлэглэлүүд / үнэлгээ	2009	2010	2011	2012	2013
Хувийн эрх ашгийг түүрүүнд тавьсан, нам тойрсон хүрээлэл	4.31	4.75	4.08	4.46	4.25
Хувийн эрх ашгийг түүрүүнд тавьсан, бизнесийн хүрээлэл	4.42	4.58	4.31	4.15	4.17
Хувийн эрх ашгийг түүрүүнд тавьсан, нэг нутаг /аймаг/ тойрсон хүрээлэл	4.00	4.08	4.31	4.08	3.83
Хувийн эрх ашгийг түүрүүнд тавьсан, нам дамжсан хүрээлэл /намуудын нэгдэл/	4.38	4.42	4.08	4.00	4.08
Хувийн эрх ашгийг түүрүүнд тавьсан, нэг хүнийг тойрсон хүрээлэл	3.77	4.00	3.69	3.77	3.83
Хувийн эрх ашгийг түүрүүнд тавьсан, найз нөхдийн хүрээлэл	3.92	3.75	3.77	3.69	3.67
Нийтийн эрх ашгийн төлөө бий болсон хүрээлэл	1.82	2.27	2.08	2.25	2.00

Хүснэгт 15. Улс төрийн бүлэглэлүүдийн хүчний үнэлгээ /2009- 2013 он/

Төрийн байгууллага дахь авлигыг бий болгоход нөлөөлж буй хүчин зүйлсийн үнэлгээ

Төрийн байгууллагад авлига бий болоход нөлөөлж буй хүчин зүйлсийг 1 – огт үгүй, 2 – бага зэрэг, 3 – дунд зэрэг, 4 – их, 5 – маш их гэсэн үзүүлэлтээр шинжээчид үнэлсэн бөгөөд 2013 онд судалгааны асуулгад оруулсан хүчин зүйлсийн үнэлгээ бүгд өндөр үзүүлэлттэй байна. Энэ байдал 2008 оноос хойшхи 6 жилийн хугацаанд тогтвортой байгаа учир авлигад нөлөөлж буй эдгээр хүчин зүйлсийг бүгдийг нь анхааран үзэх шаардлагатай гэж үзэж болохоор байна.

Зураг 17. Төрийн байгууллага дахь авлигыг бий болгоход нөлөөлж буй хүчин зүйлсийн үнэлгээ /2012, 2013 он/



Үзүүлэлт / үнэлгээ	2008	2009	2010	2011	2012	2013
Хүнд суртал	4.47	4.75	4.67	4.00	4.38	4.67
Олон шат дамжлага, давхардал	4.33	4.54	4.75	4.31	4.54	4.46
Төрийн үйлчилгээний хүртээмж хангалтгүй, шударга бус байдал	3.73	4.38	4.58	4.08	4.33	4.15
Шийдвэр гаргах ажиллагааны ил тод байдал дутмаг	4.67	4.38	4.58	4.00	4.38	4.23
Албан тушаалтны үзэмжээр асуудлыг шийдвэрлэх боломж хязгаарлагдаагүй байдал	4.86	4.23	4.33	4.23	4.23	3.92
Хууль, журам зөрчсөн албан тушаалтанд хариуцлага хүлээлгэдэггүй байдал	4.53	4.62	4.33	4.54	4.46	4.00
Хуулийн хэрэгжилтэд тавих хяналт дутагдалтай	4.40	4.15	4.75	4.46	4.69	4.23
Төсвийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалтад тавих төсвийн ерөнхийлөн захирагчид тавих хяналт сул	4.00	4.17	4.58	4.23	4.38	4.17
Албан хаагчийн цалин, орон сууц, нийгмийн баталгаа хангалтгүй	3.47	4.00	4.17	4.00	4.23	4.31
Төрийн албан хаагчийн ёс зүй, ажлын үр чадвар дутагдалтай	4.27	4.08	4.33	4.15	4.50	4.46

Хүснэгт 16. Төрийн байгууллага дахь авлигыг бий болгоход нөлөөлж буй хүчин зүйлсийн үнэлгээ /2008-2013 он/

Авлигыг бууруулахын тулд нэн тэргүүнд хэрэгжүүлэх шаардлагатай үйл ажиллагааны үнэлгээ

Шинжээчдийн ихэнх нь авлигыг бууруулахын тулд сонгуулийн тогтолцоог өөрчлөх шаардлагатай гэж үзжээ. Түүнчлэн аливаа шийдвэр гаргахад нийтийн ашиг сонирхлыг харгалзан үзэх механизм бий болгох, сонгуулийн санхүүжилтийн тогтолцоог өөрчлөх зэрэг арга хэмжээ нэн тэргүүнд шаардлагатай болох нь судалгааны дүнгээс харагдаж байна.

Шинжээчдийн зарим хэсэг нь Монгол Улсад авлигыг бууруулахын тулд иргэдийн эрх зүйн ухамсрыг нэмэгдүүлэх, намын санхүүжилтийн зарчмыг өөрчлөх зэрэг арга хэмжээ авах шаардлагатай гэж үзсэн бол цөөн хэсэг нь улс төрийн намын үйл ажиллагааны ил тод

байдлыг нэмэгдүүлэх, Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааны үр нөлөөг нэмэгдүүлэх шаардлагатай гэжээ. Харин улс төрчдийн ёс зүйн хэм хэмжээг бий болгож мөрдүүлэх нь авлигатай тэмцэхэд зайлшгүй шаардлагатай гэж нэг ч шинжээч үзээгүй байгаа нь олон нийтийн зүгээс улс төрчдөд итгэх итгэл, тэднийг өөрчлөгдөнө гэх найдвар алдагдаж байгааг харуулж байна.

Авлигыг бууруулахад шаардлагатай арга хэмжээ	%
УИХ, орон нутгийн ИТХ-ын сонгуулийн тогтолцоог өөрчлөх	53.85
Шийдвэр гаргахад нийтийн ашиг сонирхлыг харгалзан үзэх механизм бий болгох	46.15
Сонгуулийн кампанит ажлын санхүүжилтийн тогтолцоог өөрчлөх	38.46
Иргэдийн эрх зүйн ухамсрыг нэмэгдүүлэх	30.77
Намын санхүүжилтийн зарчмыг өөрчлөх	30.77
Авлигчдад хүлээлгэх эрүүгийн болон захиргааны хариуцлагыг чангатгах	23.08
Улс төрчдийн авлигатай тэмцэх хүсэл зоригийг нэмэгдүүлэх	23.08
Хээл хахууль өгсөн этгээдийг хариуцлагаас чөлөөлж, хээл хахууль авсан этгээдэд хариуцлага оноодог болох	15.38
Улс төрийн намын үйл ажиллагааны ил тод байдлыг нэмэгдүүлэх	15.38
Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааны үр нөлөөг нэмэгдүүлэх	15.38
Улс төрчдийн ёс зүйн хэм хэмжээг бий болгож мөрдүүлэх	0.00


Хүснэгт 17. Авлигыг бууруулахад нэн тэргүүнд шаардлагатай үйл ажиллагааны үнэлгээ

Шүүх эрх мэдэл, хууль сахиулах байгууллагын хүрээн дэх авлигын төсөөллийн судалгааны дүн

Шүүх, хуулийн байгууллагын авлигад өртөх эрсдлийн үнэлгээ

Шүүх эрх мэдлийн хүрээнд хамаарах шүүх, прокурорын байгууллага болон хууль сахиулах байгууллагууд болох цагдаагийн байгууллага, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагуудын авлигад өртөх эрсдлийг 1-огт үгүй, 2-бага зэрэг, 3-дунд зэрэг, 4-их, 5-маш их гэсэн үзүүлэлтээр шинжээчдээр үнэлүүлэв.

Зураг 18. Шүүх эрх мэдэл, хууль сахиулах байгууллагын авлигад өртөх эрсдлийн үнэлгээ



2013 онд шүүхийн авлигад өртөх эрсдэл дунд зэрэг байна гэж шинжээчид үзсэн бөгөөд үүнээс аймаг, нийслэлийн шүүхийн авлигад өртөх эрсдэл шүүхүүдийн дунджаас дээгүүр, харин сум буюу сум дундын, дүүргийн шүүх, Захиргааны хэргийн шүүхийн авлигад өртөх эрсдэл шүүхүүдийн дунджаас бага байна. Улсын Дээд шүүхийн авлигад өртөх эрсдлийн хэмжээ шүүхүүдийн дундажтай адил түвшинд байна.

Салбар /он	2009	2010	2011	2012	2013
Шүүх /дундаж/	3.49	3.46	3.62	2.89	3.00
Прокурор /дундаж/	3.12	3.75	3.40	2.86	3.00
Цагдаа /дундаж/	3.50	3.48	3.53	3.35	3.15
Шүүхийн шийдвэр гүйцэтгэл /дундаж/	3.21	3.30	3.50	3.02	3.15

Хүснэгт 18. Шүүх, хуулийн байгууллагын авлигад өртөх эрсдлийн үнэлгээ

Шүүхүүд	2012	2013
Сум буюу сум дундын, дүүргийн шүүх	3.00	2.92
Аймаг, нийслэлийн шүүх	3.08	3.23
Захиргааны хэргийн шүүх	2.73	2.85
Улсын Дээд шүүх	2.75	3.00
Шүүх /дундаж/	2.89	3.00

Хүснэгт 19. Шүүхийн авлигад өртөх эрсдлийн үнэлгээ

Салбар / он	2009	2010	2011	2012	2013
Сум дунд, дүүргийн прокурорын газар	3.18	3.75	3.55	3.08	3.08
Аймаг, нийслэл, тээврийн прокурорын газар	3.27	3.92	3.55	3.00	3.17
Улсын Ерөнхий прокурорын газар	2.91	3.58	3.10	2.50	2.75
Прокурор /дундаж/	3.12	3.75	3.40	2.86	3.00
Мөрдөн байцаах газар	3.82	3.75	3.73	3.33	3.54
Хэрэг бүртгэлт	3.55	3.50	3.89	3.33	3.08
Эрүүгийн цагдаагийн газар	3.82	3.50	3.70	3.17	3.31
Хэв журмын алба	2.91	3.45	3.30	3.33	2.69
Замын цагдаагийн газар	3.82	3.83	3.91	3.67	3.54
Аймаг, Нийслэл, ТЗ-ын цагдаагийн газар, хэлтэс				3.25	3.00
Цагдаагийн ерөнхий газар	3.09	2.82	2.63	3.36	2.92
Цагдаа /дундаж/	3.50	3.48	3.53	3.35	3.15
Аймгийн шийдвэр гүйцэтгэх албад	3.45	3.70	3.80	3.00	3.08
Хорих ангиуд	3.36	3.20	3.70	3.08	3.31
Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх газар	3.45	3.70	3.80	3.08	3.30
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар	2.82	3.00	3.00	2.91	2.92
Шүүхийн шийдвэр гүйцэтгэл /дундаж/	3.21	3.30	3.50	3.02	3.15

Хүснэгт 20. Хуулийн байгууллагуудын авлигад өртөх эрсдлийн үнэлгээ

2013 онд прокурорын байгууллагын авлигад өртөх эрсдэл дунд зэрэг байна гэж шинжээчид үзсэн бөгөөд сум дундын, дүүргийн, аймаг, нийслэл, тээврийн прокурорын газруудын авлигад өртөх эрсдэл энэ түвшнээс дээгүүр, Улсын ерөнхий прокурорын газрын авлигад өртөх эрсдэл прокурорын байгууллагын дунджаас доогуур байна.

Цагдаагийн байгууллагын авлигад өртөх эрсдэл 2013 онд дунд зэрэг байна гэж шинжээчид үзсэн ба цагдаагийн байгууллага дотроо Замын цагдаагийн газар, Мөрдөн байцаах газар, Эрүүгийн цагдаагийн газрын авлигад өртөх эрсдэл хамгийн өндөр, Цагдаагийн Ерөнхий газрын хамгийн бага байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын авлигад өртөх эрсдэл 2013 онд дунд зэрэг байна гэж шинжээчид үзсэн бөгөөд салбар дотроо хорих ангиуд болон нийслэлийн шийдвэр гүйцэтгэх газрын авлигад өртөх эрсдэл хамгийн өндөр, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын авлигад өртөх эрсдэл хамгийн бага байна.

2013 оны үзүүлэлтийг 2012 оныхтой харьцуулбал сум буюу сум дундын, дүүргийн шүүх, цагдаагийн хэрэг бүртгэлт, хэв журмын алба, Замын цагдаагийн газар, аймаг,

нийслэл, Төмөр замын цагдаагийн газар, хэлтсүүд, Цагдаагийн ерөнхий газрын авлигад өртөх эрсдэл буурсан байгаагаас цагдаагийн хэв журмын алба болон цагдаагийн төв байгууллагын эрсдэл хамгийн их буурчээ. Авлигын эрсдэл нь өмнөх оныхоос нэмэгдсэн байгууллагууд дотроос Улсын дээд шүүх болон Улсын Ерөнхий прокурорын газрын авлигад өртөх эрсдэл хамгийн их нэмэгдсэн байна.

2009 оноос 2013 он хүртэлх 5 жилийн дунджаар цагдаагийн байгууллагын авлигад өртөх эрсдэл хамгийн өндөр байх бөгөөд шүүх, прокурор, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын авлигад өртөх эрсдлийн дундаж нь ойролцоо түвшинд байна.

Хуулийн байгууллага дахь тодорхой үйл ажиллагааны авлигад өртөх эрсдлийн үнэлгээ

Хуулийн байгууллага дахь тодорхой үйл ажиллагааны авлигад өртөх эрсдлийн үнэлгээг 1-огт үгүй, 2-бага зэрэг, 3-дунд зэрэг, 4-их, 5-маш их гэсэн үзүүлэлтүүдээр үнэлүүлэхэд шинжээчид 2013 онд албадан дуудлага худалдаа, эрүүгийн хэрэг үүсгэх, үүсгэхээс татгалзах, хэрэгсэхгүй болгох, анхан шатны болон давж заалдах шатны шүүхээр хэргийг хэлэлцэх зэрэг эрүүгийн байцаан шийтгэх тодорхой ажиллагааны авлигад өртөх эрсдэл харьцангуй өндөр байна гэж үзжээ.

2013 оны үзүүлэлтийг өмнөх оны үзүүлэлттэй харьцуулж үзвэл албадан дуудлага худалдаа, эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах, эрүүгийн хэргийг анхан шатны шүүх болон давж заалдан шатны шүүх хянан шийдвэрлэх, захиргааны хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх, хорих ял эдлүүлэх, тодорхой хугацаагаар эрх хасах захиргааны хариуцлага ногдуулахтай холбоотой үйл ажиллагааны авлигын эрсдэл нэмэгдэж, бусад үйл ажиллагааны авлигын эрсдэл буурсан байна.

Зураг 19. Хуулийн байгууллага дахь тодорхой үйл ажиллагааны авлигад өртөх эрсдлийн үнэлгээ



Үйл ажиллагаа /он	2009	2010	2011	2012	2013
Эрүүгийн хэрэг үүсгэх	3.90	3.92	3.67	3.67	3.58
Эрүүгийн хэрэг үүсгэх санал гаргах	3.27	3.44	3.22	3.45	3.42
Эрүүгийн хэрэг яллахаас татгалзах	3.18	3.45	3.80	3.50	2.91
Тодорхой хугацаагаар эрх хасах		3.83	3.44	3.09	3.42
Торгууль ногдуулах	3.36	3.75	3.63	3.36	3.27
Эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах	3.58	4.00	4.10	3.36	3.50
Прокурор эрүүгийн хэрэг хянах	3.22	4.09	3.78	3.40	3.27
Прокурорын байгууллага эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох	3.64	4.40	3.91	3.75	3.50
Прокурорын байгууллага яллах дүгнэлт үйлдэх	3.33	3.70	3.44	3.55	3.25
Ялын хэмжээг бууруулах	3.60	4.00	4.11	3.45	3.36
Эрүүгийн хэргийг анхан шатны шүүх хянан шийдвэрлэх	3.64	3.90	3.89	3.36	3.45
Эрүүгийн хэргийг давж заалдах шатны шүүх хянан шийдвэрлэх	3.27	3.88	3.89	3.27	3.45
Эрүүгийн хэргийг хяналтын шатны шүүх хянан шийдвэрлэх		3.78	4.11	3.36	3.00
Захиргааны хэргийн шүүх хэрэг хянан шийдвэрлэх	3.00	3.38	3.44	2.73	3.09
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх /эрүүгийн/	3.40	3.50	3.55	3.36	2.75
Хорих ял эдлүүлэх		3.30	3.50	2.64	2.92
Өр барагдуулах		4.00	4.20	3.73	3.36
Хугацаанаас нь өмнө тэнсэн суллах, дэглэм бууруулах		4.13	4.00	3.09	2.91
Хорих ангид ялтан хуваарилах	3.25	3.67	3.90	3.18	2.83
Ялтныг урамшуулах	3.11	3.62	4.44	3.10	2.50
Албадан дуудлага худалдаа	3.22	3.13	3.67	3.10	4.00
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх /иргэний/	3.56	3.71	4.00	3.64	3.45

Хүснэгт 21. Хуулийн байгууллага дахь тодорхой үйл ажиллагааны авлигад өртөх эрсдлийн үнэлгээ

Авлига үүсэхэд нөлөөлж буй хүчин зүйлсийн үнэлгээ

Хууль хяналтын байгууллагад авлига үүсэхэд нөлөөлж буй хүчин зүйлсийг 1-огт үгүй, 2-бага зэрэг, 3-дунд зэрэг, 4-их, 5-маш их гэсэн үзүүлэлтээр үнэлүүлэхэд 2013 онд хууль хяналтын байгууллагын албан хаагчийн ёс зүйг сахиулах, хариуцлага тооцох механизмын дутагдалтай байдал авлига үүсэхэд хамгийн их нөлөөлсөн гэж шинжээчид үзсэн байна. Нөлөөллийн үзүүлэлтээрээ үүний дараа албан хаагчдын цалин хангамж, ажиллах нөхцөл хангалтгүй байдал орж байна.

2013 оны үзүүлэлтүүд 2012 оныхоос бүгд өссөн байх бөгөөд хуулийн байгууллагын шийдвэр гаргах үйл явц бүрэн хуульчлагдаагүй байдлын үнэлгээ болон хууль хяналтын байгууллагын албан хаагчийн цалин хангамж, ажиллах нөхцөл хангалтгүй байдал хамгийн ихээр өсчээ. Өөрөөр хэлбэл, эдгээр нөхцөл байдлын авлига үүсэхэд нөлөөлөх нөлөөлөл нь 2013 онд өссөн байна.

2009 оноос 2013 он хүртэлх 5 жилийн дундаж үзүүлэлтээр хууль хяналтын байгууллагын албан хаагчийн ёс зүй, хариуцлага тооцох механизм дутагдалтай байдал, хууль хяналтын байгууллагын албан хаагчийн цалин хангамж, ажиллах нөхцөл хангалтгүй байдал авлига үүсэхэд хамгийн ихээр нөлөөлж байсан нь 2013 оны судалгааны үр дүнтэй адил байна.

Зураг 20. Авлига үүсэхэд нөлөөлж буй хүчин зүйлсийн үнэлгээ



Авлига үүсэхэд нөлөөлж буй хүчин зүйлсийн үнэлгээ	2009	2010	2011	2012	2013
Хууль хяналтын байгууллагын шийдвэр гаргах үйл ажиллагаан дахь ашиг сонирхлын зөрчил	3.64	3.75	3.92	3.55	4.08
Хуулийн байгууллагын шийдвэр гаргах үйл явц бүрэн хуульчлагдаагүй	3.42	3.64	4.00	2.91	4.17
Хууль хяналтын байгууллагын үйл ажиллагааны давхардал, чирэгдэл, үр өгөөжгүй, хяналтгүй байдал	3.67	4.00	4.40	3.45	3.92
Хууль хяналтын байгууллагын албан хаагчийн цалин хангамж, ажиллах нөхцөл хангалтгүй	4.00	4.00	4.27	3.30	4.31
Хууль хяналтын байгууллагын албан хаагчийн ёс зүй, хариуцлага тооцох механизм дутагдалтай	3.73	4.00	4.33	4.09	4.62

Хүснэгт 22. Авлига үүсэхэд нөлөөлж буй хүчин зүйлсийн үнэлгээ


Хуулийн байгууллагын албан тушаалтан бусад албан тушаалтны үйл ажиллагаанд нөлөөлөн оролцож буй хэлбэрүүдийн тархцын үнэлгээ

Хуулийн байгууллагын албан тушаалтнаас бусад албан тушаалтны үйл ажиллагаанд хөндлөнгөөс нөлөөлөн оролцож буй үйл ажиллагааны хэлбэрүүдийн тархцыг 1 – огт үгүй, 2 – бага зэрэг, 3 – дунд зэрэг, 4 – их, 5 – маш их гэсэн үзүүлэлтээр үнэлүүлэхэд 2013 онд хууль бусаар дотоод үйл ажиллагаанд нь оролцох, шан харамж нэхэх зэрэг үйлдлийг дунд зэрэг хэрэглэсэн, харин албан тушаалтны зөрчлийг илрүүлж түүгээр нь дарамтлах, хууль бус шаардлага тавих, дарамт шахалт үзүүлэх зэрэг хэлбэрүүдийг тэдгээрээс илүү их хэрэглэсэн гэж шинжээчид үзсэн байна.

2013 онд албан тушаалтны гаргасан зөрчлөөр нь дарамт шахалт үзүүлэх хэлбэрийн үзүүлэлт өмнөх оныхоос нэмэгдэж, бусад хэлбэрийн үзүүлэлт буурснаас хууль бусаар дотоод үйл ажиллагаанд нь оролцох үйл ажиллагааны үзүүлэлт хамгийн их буурсан байна.

2009 оноос 2013 он хүртэлх 5 жилийн дунджаар албан тушаалтны зөрчлийн илрүүлж дарамтлах үйл ажиллагаа хамгийн өндөр үзүүлэлттэй байгаа бөгөөд шан харамж нэхэхтэй холбоотой хэлбэр хамгийн бага үзүүлэлттэй байна.

Зураг 21. Хуулийн байгууллагын албан тушаалтан бусад албан тушаалтны үйл ажиллагаанд нөлөөлөн оролцож буй хэлбэрүүдийн тархцын үнэлгээ (2012, 2013 он)



Хэлбэр / он	2009	2010	2011	2012	2013
Дарамт шахалт үзүүлэх	3.64	3.58	3.82	3.83	3.42
Шан харамж нэхэх	3.00	3.13	3.38	3.27	2.92
Хууль бусаар дотоод үйл ажиллагаанд оролцох	3.42	3.83	3.70	3.60	3.00
Хууль бус шаардлага тавих	3.67	3.85	3.70	3.73	3.45
Албан тушаалтны зөрчлийг илрүүлж түүгээр нь дарамтлах	4.00	4.22	4.33	3.58	3.73

Хүснэгт 23. Хуулийн байгууллагын албан тушаалтан бусад албан тушаалтны үйл ажиллагаанд нөлөөлөн оролцож буй хэлбэрүүдийн тархцын үнэлгээ, 2009-2013 он


Ашигтай, давуу байдал бий болгох шийдвэр гаргуулахын тулд хэрэглэдэг үйлдлүүдийн давтамжийн үнэлгээ

Хуулийн байгууллагын албан тушаалтнаар өөрт ашигтай шийдвэр гаргуулахын тулд хэрэглэдэг үйлдлийн давтамжийг тархацыг 1 – огт үгүй, 2 – бага зэрэг, 3 – дунд зэрэг, 4 – их, 5 – маш их гэсэн үзүүлэлтээр үнэлгээ хийлгэхэд 2013 онд мөнгө хөрөнгө өгөх, өөрт нь болон гэр бүлийхэнд нь бэлэг өгөх, ажилд оруулах зэрэг үйлдлүүдийг илүү их хэрэглэсэн гэж шинжээчид үзсэн байна.

2013 оны үзүүлэлтийг өмнөх оныхтой харьцуулбал хувьцаа өгөх болон гэр бүлийнхэнд нь өндөр үнэтэй бэлэг өгөх үйлдлүүдийн үзүүлэлт нэмэгдэж, бусад үйлдлүүдийн үзүүлэлт буурсан байна.

2009 оноос 2013 он хүртэлх 5 жилийн дундаж үзүүлэлтээр хөрөнгө, мөнгө өгөх, бэлэг өгөх, улс төрийн хамгаалалтад авах, албан тушаалд томилох зэрэг үйлдлийн үзүүлэлт хамгийн өндөр буюу хамгийн их давтамжтай, хувьцаа өгөх, гадаад банканд данс нээх, эмчилгээ сувилгаа, сургалтын зардал даах үйлдлүүдийн үзүүлэлт хамгийн бага байна.

Зураг 22. Албан тушаалтнаар ашигтай, давуу байдал бий болгох шийдвэр гаргуулахын тулд хэрэглэдэг үйлдлүүдийн давтамжийн үнэлгээ (2012, 2013)



Үйлдэл /он	2009	2010	2011	2012	2013
Мөнгө /хөрөнгө/ өгөх	4.08	4.08	4.44	4.09	3.82
Хувьцаа өгөх	2.00	3.00	3.00	1.71	2.57
Гадаад банкинд данс нээж өгөх	1.67	2.50	3.67	2.14	2.00
Олсон ашиг, орлогоо хуваахаар амлах	3.30	4.00	3.86	3.80	3.36
Аялал, жуулчлалын зардал даах	2.91	3.38	2.57	3.40	3.11
Гадаад арга хэмжээний зардал даах	2.50	3.75	3.17	3.45	3.13
Бэлэг өгөх	4.08	4.09	3.90	4.18	3.75
Ажилд оруулах	2.50	3.40	3.33	-	3.55
Эмчилгээ, сувилгааны зардал даах	2.63	3.17	2.71	3.10	3.13
Сургалтын зардал даах	2.63	3.25	2.86	3.00	2.78
Шаардлагагүй албан тушаал бий болгох	-	-	-	3.78	3.09
Бооцоот тоглоомд санаатайгаар хожигдох	2.89	4.22	3.88	3.11	3.00
Зээл өгөх	-	-	-	3.40	3.09
Гэр бүлийнхэнд нь өндөр үнэтэй бэлэг өгөх	3.11	3.83	3.38	3.00	3.56
Өр, зээлийг нь төлөх	3.33	3.75	3.44	3.00	2.60
Төрийн одон, медаль, шагналаар шагнах	3.14	3.71	4.00	3.10	3.00
Албан тушаалд томилох	3.60	3.73	3.80	3.55	3.25
Улс төрийн хамгаалалтанд авах	2.83	4.14	4.29	3.60	3.20
Хэн нэгэнд зориулж ажлын байр шинээр бий болгох	3.00	3.25	4.00	3.78	2.99


Хүснэгт 24. Албан тушаалтнаар ашигтай, давуу байдал бий болгох шийдвэр гаргуулахын тулд хэрэглэдэг үйлдлүүдийн давтамжийн үнэлгээ (2009- 2013)

Шүүх, хуулийн байгууллагын хүрээн дэх авлигын өртөг

Шүүх, хуулийн байгууллагын тодорхой үйл ажиллагааны үе дэх авлигын өртгийн талаарх мөнгөн дүнгээр илэрхийлэгдсэн үзүүлэлт бүхий таамаглал болон төсөөллийн үнэлгээг шинжээчдээр хийлгэв. 2013 оны судалгааны хүрээнд шинжээчдийн төсөөллөөр ажил, албан тушаалд ороход 7.7 сая төгрөг, эрүүгийн хэрэг үүсгэхэд 2.1 сая төгрөг, ашиг сонирхолдоо нийцсэн шийдвэр гаргуулахад 5.3 сая төгрөг, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын үед хэрэг хэрэгсэхгүй болгоход 10.2 сая төгрөг, шүүхэд хэргийг хэрэгсэхгүй болгоход 15.8 сая төгрөг авлигад зарцуулагддаг байж болзошгүй байна.

2013 оны үзүүлэлтийг өмнөх оныхтой харьцуулбал шүүхэд хэргийг хэрэгсэхгүй болгоход зарцуулдаг байж болох авлигын өртгийн хэмжээний төсөөллийн үзүүлэлт 2.6 сая төгрөгөөр нэмэгдэж дурдагдсан бусад үйл ажиллагааны үе дэх авлигын өртгийн хэмжээний төсөөллийн үзүүлэлтүүд буурчээ. Үүнд ажил, албан тушаалд орох үеийн авлигын өртгийн хэмжээний төсөөллийн үзүүлэлт 23.7 сая төгрөгөөр буурсан бол ашиг сонирхолдоо нийцсэн шийдвэр гаргуулахад зарцуулдаг авлигын өртгийн хэмжээний төсөөллийн үзүүлэлт 11.5 сая төгрөгөөр, эрүүгийн хэрэг үүсгэхтэй холбоотой авлигын өртгийн хэмжээний төсөөллийн үзүүлэлт 12.2 сая төгрөгөөр тус тус буурсан байна. Хэрэг бүртгэх, мөрдөн байцах шатанд хэргийг хэрэгсэхгүй болгохтой холбоотой авлигын өртгийн хэмжээний төсөөллийн үзүүлэлт 2012 оныхоос 2013 онд 2.5 сая төгрөгөөр буурсан нь дээрх үзүүлтүүдээс харьцангуй доогуур байна.

Зураг 23. Шүүх, хуулийн байгууллагын хүрээнд авлигын өртөг, сая төгрөгөөр (2012, 2013 он)



Авлигын хэлбэрийн үнэлгээ

Хууль сахиулах болон шүүх эрх мэдлийн байгууллагын албан тушаалтанд хээл хахууль өгөх, авах арга тус бүрийн тархацыг 1-огт үгүй, 2-бага зэрэг, 3-дунд зэрэг, 4-их, 5-маш их гэсэн үзүүлэлтээр үнэлүүлэхэд 2013 онд өмгөөлөгчөөр болон зуучлагчаар дамжуулан хээл хахууль өгөх, эд зүйлсийг зах зээлийн үнээс дээгүүр үнээр худалдан авах, ойр дотнын хүмүүсээр нь дамжуулан хээл хахууль өгөх зэрэг хэлбэрүүд харьцангуй илүү тархалттай байна гэж шинжээчид үзсэн байна.

2013 онд 2013 оны судалгааны дүнг өмнөх оны дүнтэй харьцуулбал мөнгө зээлдүүлээд мартаж үйлдлээс бусад хэлбэрийн үзүүлэлт буурсан байна. Үүнд хувьцаа, эд хөрөнгө өмчлүүлэх, хахууль авагчид шууд өөрт нь өгөх, ойр дотнын хүмүүсээр нь дамжуулах зэрэг үйлдлүүдийн үзүүлэлт хамгийн их буурчээ.

2009 оноос 2013 оны хоорондох 5 жилийн дундаж үзүүлэлтээр өмгөөлөгчөөр болон зуучлагчаар дамжуулах, ойр дотнын хүн, гэр бүлийн гишүүд, тэдгээрийн өмчийн компанид давуу байдал олгох зэрэг үйлдлүүд хамгийн өндөр үзүүлэлттэй байхад хувьцаа, эд хөрөнгө өмчлүүлэх, эд зүйлийг зах зээлийн үнээс доогуур үнээр худалдах зэрэг үйлдлүүд хамгийн бага үзүүлэлттэй байна.

Зураг 24. Авлигын хэлбэрийн үнэлгээ



Хэлбэр / он	2009	2010	2011	2012	2013
Шууд өөрт нь өгөх	2.90	3.17	3.64	3.56	2.78
Зуучлагчаар дамжуулах	3.60	3.73	4.20	3.82	3.55
Өмгөөлөгчөөр дамжуулах	3.80	3.82	4.11	4.10	3.67
Ойр дотны хүмүүсээр нь дамжуулах	3.00	3.22	3.67	3.90	3.20
Хувьцаа, эд хөрөнгө өмчлүүлэх	2.29	2.80	2.86	3.43	2.20
Ойр дотны хүн, гэр бүлийн гишүүд, тэдгээрийн өмчийн компанид давуу байдал олгох	3.33	3.33	3.88	3.75	3.11
Эд зүйлсийг зах зээлийн үнээс доогуур үнээр худалдах	3.00	3.14	3.63	3.10	2.89
Эд зүйлсийг зах зээлийн үнээс дээгүүр үнээр худалдан авах	3.00	3.17	3.86	3.86	3.33
Мөрийтэй тоглож санаатайгаар алдах	2.78	3.63	3.75	3.14	2.60
Мөнгө зээлдүүлээд мартаг	3.44	3.57	3.63	2.86	2.90

Хүснэгт 25. Авлигын хэлбэрийн үнэлгээ

Авлигын улмаас бий болсон хөрөнгө, орлогын зарцуулалтын үнэлгээ

Хууль сахиулах болон шүүх эрх мэдлийн байгууллагын албан тушаалтнууд авлигаар олсон хөрөнгөө хэрхэн зарцуулдаг талаарх шинжээчдийн төсөөллийг 5-тигм, 1-үгүй, 3-эргэлзэж байна гэсэн үзүүлэлтээр үнэлүүлэв. 2013 онд өөрийн болон гэр бүлийн бизнест хувь оруулах, өдөр тутмынхаа хэрэгцээнд зориулах, хүүхдийнхээ сургалтын төлбөрт зориулах, зугаа цэнгэлд зарцуулах, орон сууц худалдан авах зэрэг хэлбэр илүү байсан гэж шинжээчид нар үзсэн байна.

2013 оны үзүүлэлтийг өмнөх оны үзүүлэлттэй харьцуулбал үл хөдлөх хөрөнгө худалдан авах, гадаадын банканд хадгалах, машин худалдан авах, зугаа цэнгэлд зарцуулах зэрэг хэлбэрүүдийн үзүүлэлт буурсан бол өдөр тутмын хэрэгцээнд зарцуулах, хүүхдийн сургалтын төлбөрт зарцуулах, хувьцаа худалдан авах, дотоодын банкинд хадгалах зэрэг хэлбэрийн үзүүлэлт өссөн байна.

Зураг 25. Авлигын замаар олсон хөрөнгийн зарцуулалтын хэлбэрийн үнэлгээ



Зарцуулалт /он	2009	2010	2011	2012	2013
Өдөр тутмынхаа хэрэгцээнд зориулах	4.75	4.78	5.00	4.80	5.00
Дотоодын банкинд хадгалдаг	3.25	3.00	4.00	3.00	3.29
Гадаадын банкинд хадгалдаг	2.64	3.00	3.80	3.67	2.71
Хувьцаа худалдан авдаг	2.83	3.00	3.86	2.43	3.33
Машин худалдан авдаг	5.00	4.56	4.78	4.00	3.67
Орон сууц худалдан авдаг	3.33	4.56	4.78	4.00	4.00
Үл хөдлөх хөрөнгө худалдан авдаг	5.00	4.25	1.00	4.11	3.67
Өөрийн болон гэр бүлийн бизнест хувь оруулах	3.00	3.67	4.43	5.00	5.00
Зугаа цэнгэлд зарцуулдаг	5.00	4.78	4.50	4.40	4.33
Хүүхдийнхээ сургалтын төлбөрт зориулдаг	3.33	4.50	5.00	4.25	4.75

Хүснэгт 26. Авлигын замаар олсон хөрөнгийн зарцуулалтын хэлбэрийн үнэлгээ

Шүүх, хуулийн байгууллагын хүрээн дэх авлигыг бууруулахад шаардлагатай арга хэмжээний ач холбогдлын түвшин

Шүүх, хуулийн байгууллагын хүрээн дэх авлигыг бууруулахад шаардлагатай арга хэмжээний ач холбогдлыг түвшинг шинжээчдээр 1-огт шаардлагагүй, 2-нэг их шаардлагатай биш, 3-эргэлзэж байна, 4-ер нь шаардлагатай, 5-нэн тэргүүнд шаардлагатай гэсэн үзүүлэлтүүдээр үнэлүүлэхэд хууль хяналтын байгууллагын чадавхийг сайжруулах, ур чадварт үндэслэн томилгоо хийх, байгууллагын ил тод байдлыг нэмэгдүүлэх, албан тушаалтныг чөлөөлөх, өөрчлөх, халах шударга, ил тод механизм бий болгох, албан хаагчдын цалин хөлсийг нэмэгдүүлэх, албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх механизмыг боловсронгуй болгож хэрэгжүүлэх, тогтвортой ажиллах баталгааг сайжруулах зэрэг арга хэмжээ нэн тэргүүнд шаардлагатай гэж шинжээчид үзсэн байна.

Зураг 26. Авлигыг бууруулахад шаардлагатай арга хэмжээний ач холбогдлын түвшин



ДҮГНЭЛТ

- ✚ Улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын талаарх төсөөллийн судалгаа 2008 оноос хийгдэж эхэлснээс хойшхи 6 жилийн хугацааны хамгийн бага үзүүлэлт буюу 3.68 гэсэн үзүүлэлттэй гарлаа. Ингэж гарахад улс төрийн хүрээний авлигын төсөөллийн 2013 оны үзүүлэлт 2012 оныхоос 0.3 пунктээр буурсан нь голлон нөлөөлсөн байна.
- ✚ Монгол Улс дахь улс төрийн институциудын авлигад өртөмтгий байдлын дундаж үзүүлэлт жил бүр буурч байгаа нь эерэг үзүүлэлт болж байна.
- ✚ Уул уурхай, дэд бүтэц, барилгын салбарт улс төрийн хүрээний авлигын үйл ажиллагаа голлон чиглэгдэж байгаа болон төрийн захиргааны төв байгууллагуудын дээд болон дунд түвшний удирдлагын авлигад өртөх эрсдэл өндөр байгаа нь судалгааны үр дүнгээс харагдаж байна. Эндээс уул уурхай, дэд бүтэц, барилга хот байгуулалтыг хариуцсан салбарын яамдын удирдах албан тушаалтнууд авлигад холбогдох эрсдэл ихтэй гэж дүгнэж болохоор байна.
- ✚ Төрийн албан дахь төрийн томилгоо болон бизнес бүлэглэлүүдийн ашиг сонирхол улс төрд нөлөөлж буй байдал нь улс төрийн хүрээний авлигад хүчтэй нөлөөлж буй хүчин зүйлс болоод байна. Эдгээрээс гадна улс төрийн намын санхүүжилтийн механизм, сонгуулийн санхүүжилтийн механизм, сонгуулийн өнөөгийн тогтолцоо зэрэг улс төрийн нам, сонгуультай холбоотой хүчин зүйлс улс төрийн хүрээний авлига үүсэхэд ихээхэн нөлөөлж байна. Улсын Их Хурлын үйл ажиллагаан дахь ашиг сонирхлын зөрчил нь мөн улс төрийн авлигад их нөлөөтэй болохыг судалгааны дүн харуулж байна.
- ✚ Улс төрийн авлигын олон хэлбэрүүдээс нам болон сонгуулийн үйл ажиллагаатай холбоотой, ялангуяа намын болон сонгуулийн санхүүжилтийн асуудал илүү ноцтой байна.
- ✚ Төрийн албан тушаалтнаар өөрт ашигтай, давуу тал бий болгох шийдвэр гаргуулахын тулд олон янзын арга зам хэрэглэдэг боловч тухайн албан тушаалтанд мөнгө хөрөнгө өгөх, түүнийг албан тушаалд томилох, цалин өндөртэй ажилд оруулах, олсон ашиг орлогоо хуваахаар амлах, өр зээлийг нь төлөх зэрэг арга замуудыг ихээхэн ашигладаг болохыг судалгааны дүн харуулж байна. Албан тушаалын томилгооны асуудал энд мөн дурдагдаж байгаад анхаарал хандуулах шаардлагатай.
- ✚ Улс төрчдийн зүгээс албан тушаалын томилгоо, тусгай зөвшөөрөл, төрийн үйлчилгээ, шүүх, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, мэргэжлийн хяналт зэрэг хяналтын үйл ажиллагаа, татвар зэрэг төрийн янз бүрийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс хутгалдан оролцож, нөлөөлөхдөө ихэнхдээ холбогдох албан тушаалтанд дарамт шахалт үзүүлдэг болохыг судалгаа харуулж байна. Энэ байдлаас улс төрчдийн ёс зүйн хэм хэмжээ ихээхэн алдагдсан, тэдэнтэй хариуцлага тооцох механизм сул байгаа гэж дүгнэж болохоор байна.
- ✚ Улс төрийн хүрээний авлига уул уурхай, дэд бүтцийн салбартай ихээхэн холбогдож байгаа нь Монгол Улсын эдийн засгийн хөгжилд ноцтой хохирол учруулж болзошгүй байна.
- ✚ Улс төрийн хүрээний авлига нь намд хандив авах, хувийн ашиг сонирхолдоо нийцсэн шийдвэр гаргах, ийм шийдвэр гаргуулахын тулд лоббидох, улс төрийн зорилготой хандив өгөх, авах, сонгогчдын саналыг худалдан авах, төрийн өмчийг ашиглан шамшигдуулах, хувьдаа завших, өөрийн эрх мэдлээ худалдах, бизнесийн бүлэглэлийн

нөлөөнд автах зэрэг хэлбэрээр зонхилон илэрч байгаа нь Монгол Улс дахь улс төр болон бизнесийн бүлэглэлүүд хоорондоо нэгдэж нэг ашиг сонирхолтой болсон байж болзошгүй, бизнесийн бүлэглэлүүд улс төрчдийг гартаа оруулж өөрсдийн хүссэн шийдвэрийг гаргуулах боломжтой болсонтой холбоотой байж болох юм.

- ✚ Улс төрийн хүрээн дэх эрх ашгийн эрэмбээр нийтийн эрх ашиг хамгийн доод түвшинд байна.
- ✚ Улс төрийн авлига илүү их зохион байгуулалттай, илүү далд хэлбэртэй болж байгаа нь цаашид ноцтой үр дагаварт хүргэж болзошгүй байна.

САНАЛ, ЗӨВЛӨМЖ

- ✚ Уул уурхай, дэд бүтэц, барилгын салбарын төрийн захиргааны байгууллагуудын удирдах албан тушаалтнуудын авлигын өндөр эрсдэлтэй байгааг анхааран холбогдох урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх арга хэмжээ авах шаардлагатай. Түүнчлэн албан тушаалын томилгоог улс төрийн намын харьяалал, танил тал, нэг аймаг, нэг нутаг, найз нөхөр гэсэн байдлаар хийхгүй байх нөхцөлийг бүрдүүлэх нь чухал байна.
- ✚ Улс төрийн авлигын олон хэлбэрүүдээс нам болон сонгуулийн үйл ажиллагаатай холбоотой, ялангуяа намын болон сонгуулийн санхүүжилтийн асуудал илүү ноцтой байгаад анхаарал хандуулж, холбогдох эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, улс төрийн шинжтэй, намын гишүүнчлэлээр албан тушаалд томилдог байдлыг өөрчлөх шаардлагатай.
- ✚ Нийтийн эрх ашгийг эрхэмлэн дээдлэх, ёс зүйтэй байх, хариуцлага хүлээх чадвартай байх явдал улс төрчдөд дутагдаж байгаад анхаарал хандуулах хэрэгтэй байна. Улс төрийн үйл ажиллагааг бизнесийн үйл ажиллагаанаас зааглах, төрийн үйл ажиллагаанд намчирхдаг, нутгархдаг байдлыг таслан зогсоох шаардлагатай. Үүний тулд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн зохицуулалтыг улам боловсронгуй болгох, уг хуулийг хэрэгжүүлэх, хэрэгжилтэд нь хатуу хяналт тавих, зөрчил бүрд арга хэмжээ авах, улс төрчдөд ёс зүйн хариуцлага хүлээлгэх механизмыг бүрдүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.
- ✚ Төрийн байгууллага дахь авлига бий болоход голлон нөлөөлж буй хүчин зүйлсийн эсрэг шаардлагатай арга хэмжээ авах, үүнд төрийн албан хаагчдын ёс зүй, ажлын ур чадварыг дээшлүүлэх, тэдний цалин, нийгмийн баталгаатай холбоотой асуудлуудыг шийдвэрлэх, төсвийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалтад тавих хяналтыг чангатгах, албан тушаалтан өөрийн үзэмжээр асуудлыг шийдвэрлэдэг байдлыг таслан зогсоох эрх зүй, зохион байгуулалт, хүний нөөцийн холбогдох арга хэмжээ авах, төрийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, олон шат дамжлагыг цөөлөх шаардлагатай.
- ✚ Хууль сахиулах болон шүүх эрх мэдлийн байгууллага дахь авлига, ашиг сонирхлын зөрчлийг арилгахын тулд юуны өмнө тухайн байгууллагын чадавхийг бэхжүүлэх, үүний тулд ур чадварт үндэслэсэн томилгоо хийх, байгууллагын ил тод байдлыг нэмэгдүүлэх, хяналт тавих, хариуцлага хүлээлгэх тогтолцоог боловсронгуй болгох нь зүйтэй.